# Сухбаатар аймаг Цусны салбар төв

2019 оны үндсэн болон онцлох үйл ажиллагааны товч тайлан

# * Үндсэн үйл ажиллагаа-цус цуглуулалт

**Донорт сургалт:**

* 01 сарын 03нд зэвсэгт хүчний 338р анги 22 шинэ донороос цус цуглуулсан
* 02 сарын 03нд Сүхбаатар аймгийн Онцгой байдлын газарт 45 албан хаагчдад донорын тухай сургалт явуулж, 20 донороос цус цуглуулсан
* 04 сарын 03нд 338-р ангийн 84 ахлагч албан хаагчидад донорын тухай сургалт явуулж 15 донороос цус цуглуулсан
* 05 сарын 03нд 7-р цэцэрлэгийн 10 ажилчдад сургалт явуулж 5 донор шинээр элсүүлж цус цуглуулсан.
* 06 сарын 03нд ‘Сүхбаатар аймгийн эмэгтэйчүүдийн “СИЙЛЭНГОО групп” цус бэлэглэх аянд нэгдэж УЗХ-нд өдөрлөг зохион байгуулж тус өдөрлөгөөр 11 донор цус бэлэглэж 8 донор шинээр элссэн байна.
* 11 сарын 04нд Баруун-Урт сумын тамгын газрын ажилтан залуучууд нэгдэн 3 донор шинээр элсэж цусаа бэлэглэсэн.
* 12 сарын 03нд Монгол даатгал компаний Сүхбаатар аймаг дах салбарын ажилчид ирж донорын эгнээнд нэгдлээ. 7н ажилчидаас 4нь донорын эгнээнд нэгдэж цусаа бэлэглэлээ.

Жилийн 12 сарын 7 сард сар бүрийн 3ний цус цуглуулах үйл ажиллагааг зохион байгуулж, нийт сургалтанд хамрагдсан хүний тоо 181 үүнээс цусаа бэлэглэсэн донорын тоо – 73 /шинэ донор-67, байнгын  донор- 9/

*

# *Цус сийвэн цуглуулалт

* Нийт сууринд 60 цувралаар 163 донороос цус цуглуулсан байна.
* Явуулаар – 5 цувралаар 73 донороос цус цуглуулсан.
* Нийт 236 донороос /Шинэ донор-69/ сууринд 61.25 литр, 5 удаагийн явуулаар 27.2 литр нийт **88.45 литр** цус цуглуулж **536 нэгж /108.23л/** ЦЦБ үйлдвэрлэсэн байна.

54 нэгж буюу 14.7литр ДУЭ хугацаа дуусч, 2 нэгж 0,4 л К сийвэн хадгалалтын явцад гэзэг гуурс гэмтсэн шалтгаанаар актлагдсан байна. Актлагдсан бүтээгдэхүүн нь үйлдвэрлэсэн нийт бүтээгдэхүүний 10%-ийг, улаан эсийн бүтээгдэхүүний 23%-ийг эзэлж байна.

# *Акт:

# *Шинжилгээ

Цусны АВО резус бүлэг тодорхойлох шинжилгээ - 1894 хүнд хийсэн ба резус сөрөг бүлэг 7 илэрсэн /1 хүүхэд сөрөг.

1178 жирэмсэн эмэгтэйн цусны бүлэг тодорхойлох шинжилгээ хийснээс 6н тохиолдол сөрөг бүлэг байсан. Резус бүлэг сөрөг илэрсэн жирэмсэн эмэгтэйчүүдийг жирэмсний хяналтын амбулаторийн эмчид гараас гарт хүлээлгэн өгч ажиллаж байна.

Цусны хувийн тохирооны шинжилгээг лабораторит 172 удаа хийсэн ба 142 удаагийн сэлбэлттэй байна Т:С – 172:142

Шинжилгээгээр хасагдсан донорын тоо 8 буюу нийт цусаа бэлэглэсэн донорын 3,3%ийг эзэлж байна. /тэмбүүгийн халдвар 6, Гепатит С вирусын халдвар-2/

# *Үйлдвэрлэл

**ЦЦБ-ний үйлдвэрлэлийн талаар:**

* Улаан эсийн бүтээгдэхүүн - 234 нэгж
* ДУЭ – 219 нэгж
* УЭӨ – 8 нэгж
* ЦЭУЭБ – 7 нэгж
* Сийвэнгийн бүтээгдэхүүн – 298 нэгж
* ХШС- 240 нэгж
* К сийвэн- 29нэгж
* Криоприципитат – 29 нэгж
* Эсийн бүтээгдэхүүн ЯЭӨ – 4 нэгж /нэгтгэж савласан 8 донороос/

Энэ онд А бүлгийн сийвэн криопреципитатын хэрэглээ нэмэгдэж нөөц багассан тул ЦССҮТөвөөс 41 нэгж ХШС, 30 нэгж Крио захиалж авч эмчилгээний нөөцийг хангаж ажилласан.

Улаан эсийн бүтээгдэхүүнийг ЭЭОДаргын баталсан журмын дагуу бүлэг бүрээс 4оош доошгүй нэгж нөөцөнд байлгаж хэрэглээ гарсан тухай бүрд нөхөн нөөцөлж улаан эсийн бүтээгдэхүүний хомсдолгүй ажиллаж байна.

Энэ онд долоон нэр төрлийн 536 нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 71 нэгж 2 нэр төрлийн сийвэнгийн бүтээгдэхүүнийг ЦССҮТ-өөс татан нөөц хангалт хийж ажилласан байна.

# * Цус цусан бүтээгдэхүүний хэрэглээ /нэгжээр/

| Олгосон тасаг нэгж | 2017 онд | 2018 онд | 2019 онд |
|---|---|---|---|
| Мэс засал | 60 | 48 | 21 |
| Төрөх/нярай | 153 | 155 | 113 |
| Дотор | 184 | 184 | 204 |
| Хүүхэд | 23 | 29 | 36 |
| Хавдар | 21 | 18 | 21 |
| МЭЭТ | - | 30 | 28 |
| Бусад тасгууд | 4 | 13 | 6 |
| Нийт | 445 | 480 | 429 |

# * Эмнэлгийн эмч мэргэжилтнүүдэд сургалт

* 2019.04 сард шинээр ажилд орж буй 12 сувилагч нарт Цусны аюулгүй байдал, ЦЦБ-нийг зөөвөрлөх, сэлбэх тухай сургалт
* 2019.05 сард дотоод хяналтаас гаргасан зөвлөмжийн дагуу халдварт сүрьеэгийн тасгийн 11 сувилагч тусгай мэргэжилтэнд ЦЦБ-ний сэлбэлтэнд анхаарах, анхан шатны маягт бүртгэл хөтлөх мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.
* Цус цусан бүтээгдэхүүн сэлбэдэг тасаг нэгжүүдэд шинээр орсон сувилагч нар сэлбэх бүтээгдэхүүн авахаар цусны салбар төвд орж ирэх бүрт газар дээрхи сургалтыг явуулж аюулгүй сэлбэлтийн талаар заавар зөвлөмж өгч ажиллаж байна.
* 2019.10.23нд Оточ болор хувийн эмнэлгийн эмч эмнэлгийн мэргэжилтэн 7 ажилтанд сургалтын хөтөлбөрийн дагуу **“Цусны аюулгүй байдал, ЦЦБ сэлбэхэд анхаарах зүйл, цусны АВО резус бүлэг тодорхойлох нь”** сэдэвт сургалтыг хийж ном гарын авлагаар хангав.
* Сургалтанд хамрагдсан нийт эмч эмнэлгийн мэргэжилтнүүдийн тоо- 40

# *Сум өрхийн эрүүл мэндийн уялдаа холбоо

2019 оны 06 сард 12 сумын эрүүл мэндийн төвийн эрхлэгч их эмч, эх баригч, статистик нартай цахим хурлаар донорын эгнээг өргөжүүлэх, цусны аюулгүй байдлын тухай шинэ гарсан тушаалуудыг танилцуулж, донорын баяр тэмдэглэн өнгөрүүлэх тухай албан бичгийг хүргүүлж, хийсэн үйл ажиллагааны тайланг ЭМГ-т 2019.06.30нд ирүүлэхээр ажилласан.

12 сумаас 9 сумд тодорхой ажлуудыг зохион байгуулж, донорын шинэчилсэн бүртгэлтэй болж, донор алдаршуулах урамшуулах ажил хийн тайланг ирүүлсэн.









# *Зурагт хуудас


UNIVERSALITY
HUMANITY
НЭРЭНГҮЙ
HUMANITY


СҮХБААТАР АЙМАГ
ЦУСНЫ САЛБАР ТӨВ
Таны ЦУС
БУСДАД АМЬДРАЛ
БЭЛЭГЛЭНЭ
Бид ЦУСАА бэлэглэж
Бусдад АМЬДРАЛ хайрлана.
СҮХБААТАРЫН
БҮСГҮЙЧҮҮД БИД
ЦУСНЫ ДОНОРЫН
ЭГНЭЭНД НЭГДЭЖ
БАЙНА


Цусны аюулгүй байдал


ТАНЫ МЭДЭХ ЁСТОЙ 5 ЗҮЙЛ
АЛЬ Ч БҮЛГИЙН ЦУСТАЙ ХҮН ДОНОР БОЛОХ БОЛОМЖТОЙ
Цусаа бэлэглэж
17+
+45кг
AB

Анхаарал хандуулсанд баярлалаа.

**АМЖИЛТ**

